



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/256

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих ГААОНӨГ/202101006 дугаар бүхий “Газар тариалан, жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээний Багц-7 буюу Бигэр сумын Мянгай Бургас, Дэлгэр сумын Дагналтай, Тайшир Хуримт, Шарга сумын Тэгш, Урд голын услалтын системүүдийг засварлах ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг сумдын Засаг дарга нарт олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ж.Мөнхцэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ